



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 23.

Есөнбулаг сум

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "Н", 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам"-ыг нэгдүгээр, "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний загварыг хоёрдугаар, гэрээний биелэлтийг дүгнэх хүснэгтийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам". "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний загварыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангахыг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагууд, Орон нутгийн өмчийн газар /З.Мөнхнасан/-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д тус тус үүрэг болгосугай.

3. Уг тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 293 дугаар захирамжийг хүчингүй болгохыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ  
БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ ЖУРАМ**

**Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Орон нутгийн өмчийг эзэмшигч байгууллагаас эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, хөрөнгийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу данс бүртгэлд тусгах, тайлагнах өмчийн талаарх хууль, тогтоомж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох бусад байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх талаар гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэхэд энэхүү журмын зорилго оршино.

**Хоёр. ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 4 хүртэл жилийн хугацаатайгаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулж, жил бүр дүгнэн ажиллана.

2.2. Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал, эрхлэгч/-тай орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг байгуулна.

2.3. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө болон холбогдох бусад мэдээллийг хавсаргах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг болно.

2.4. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээнд хавсаргах мэдээллийг эрх бүхий байгууллагын баталсан төрийн өмчийн мэдээлэл, бүртгэл статистикийн холбогдох маягтын дагуу гаргаж, дагалдах баримт мэдээллээр баяжуулсан байна.

2.5. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээнд нэг талаас орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал, эрхлэгч/, нягтлан бодогч, нөгөө талаас аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга болон мэргэжилтэн гарын үсэг зурна.

2.6. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг байгуулсан этгээд нь зохих журам зааврын дагуу гэрээнд дугаар олгож, тамга тэмдгээр баталгаажуулна.

2.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, нягтлан бодогч өөрчлөгдсөн тохиолдолд орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулна.

**Гурав. ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭГ ДҮГНЭХ**

3.1. Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг жил бүрийн 2 дугаар улиралд багтаан дүгнэнэ.

3.2. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар томилогдсон Ажлын хэсэг (мэргэжилтэн) дүгнэнэ.

3.3. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дор дурдсаны дагуу үндсэн шалгуур үзүүлэлтээр оноо өгч тооцно.

д/д	Үндсэн шалгуур	Авбал зохих оноо
1	Хөрөнгийн хөдөлгөөний талаар	25
2	Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар	25
3	Түрээсийн талаар	10
4	Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн сангийн	15

	бүрдүүлэлт	
5	Байгууллагын эзэмшил газрын талаар	10
6	Бэлгэл ажлыг хангасан талаар	15
Нийт оноо		100

3.4. Ажлын хэсэг орон нутгийг өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг журмын хавсралт (Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний ... оны биелэлтийг дүгнэх хуудас) дахь түлхүүр үзүүлэлт тус бүрээр тооцож, дүнг нэгтгэж гаргана.

3.5. Энэхүү журмын 3.3-т заасан үндсэн шалгуур үзүүлэлтийн нийт дүнгээр 96-100 оноо авсан бол “Бүрэн хангалттай”, 76-95 оноо авсан бол “Хангалттай”, 75-аас доош оноо авсан бол “Хангалтгүй” гэж тус тус үнэлж дүгнэнэ.

3.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний тухайн жилийн биелэлтийг дүгнүүлэхэд дор дурдсан бэлтгэлийг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан хангасан байна.

3.6.1 Төрийн болон орон нутгийн өмчийг мэдээлэлжүүлэх системд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл, үндсэн хөрөнгө, газар эзэмших (ашиглах) эрх тэдгээртэй холбогдох хавсралт мэдээлэл, санхүүгийн тайлан, хөрөнгийн хөдөлгөөн болон бусад мэдээллийг бүрэн тусгаж баталгаажуулах\

3.6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тухайн жилийн дэлгэрэнгүй тайланг Төрийн болон орон нутгийн өмчийг мэдээлэлжүүлэх системийн “Тайлан мэдээ” цэсний “Дэлгэрэнгүй тайлан” хэсгээс гаргаж, цаасан болон цахим хэлбэрт бэлтгэх

3.6.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөл тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргах,

3.6.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн дотоодын тооллогын хагас, бүтэн жилийн дүн, тайлан, газар эзэмших (ашиглах) эрхийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн хувьд барилгын хувийн хэрэг болон холбогдох шийдвэрийн хуулбарыг бэлтгэх,

3.6.5. Эд хөрөнгийн дотоодын тооллогын дүнд үндэслэн илүүдэл болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг актлах, худалдах, шилжүүлэх тухай санал бэлтгэх

3.6.6. Түрээсийн төлбөрийн зохих хууль журмын дагуу бүрэн төвлөрүүлж, Орон нутгийн өмчийн газартай тооцоо нийлсэн баримтын хуулбарыг бэлтгэх

3.6.7. Орон нутгийн өмчийн газар болон эрх бүхий байгууллагын хөрөнгийн зохицуулалттай холбоотой шийдвэр, түүний биелэлт гаргах

3.6.8. Жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан (үндсэн хөрөнгийн тодруулга, аудитын тайлан, зөвлөмжийн хамт)-г хуулбарлан бэлтгэх,

3.6.9. Холбогдох байгууллагаас баталсан төрийн өмчийн захиргааны статистик мэдээ (ТӨ маягт)-г жил бүрийн 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймгийн Орон нутгийн өмчийн газарт цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн байх

3.6.10. Орон нутгийн өмчийн газраас гэрээ дүгнэхэд шаардлагатай гэж үзсэн бусад судалгаа, мэдээлэл баримт бичгийг бэлтгэх

3.6.11. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх хуудасны тайлбар хэсгийг бүрэн бөглөх (2 хувь үйлдэх)

3.8. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх ажлын хэсэг (мэргэжилтэн) орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын байдалтай газар дээр нь танилцаж, шаардлагатай гэж үзвэл байгууллагын

санхүүгийн тайлан, хөрөнгийн бүртгэлээс тодруулж болно.

3.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх хуудаст гэрээг байгуулсан 2 тал гарын үсэг зурж, зохих журам, зааврын дагуу тамга, тэмдгээр баталгаажуулна.

3.10. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээнд гэрээний сунгалт, гэрээ дүгнэсэн хуудас болон үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тухай жилийн дэлгэрэнгүй мэдээ /Маягт-ТӨ-2, Маягт-ТӨ-11/-г жил бүр хавсаргана.

#### **Дөрөв. БУСАД**

4.1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар орон нутгийн өмчийн тухайн жилийн үр дүнг хэлэлцэж, өмч эзэмшигч байгууллагын гэрээний биелэлтийн дүгнэлтийг үндэслэн “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан тохиолдолд зохих хууль тогтоомжийн хүрээнд ажил хариуцсан албан тушаалтан /захирал, дарга, эрхлэгч, ня-бо, нярав/, өмч хамгаалах байнгын зөвлөлийг урамшуулах ба “Хангалтгүй” үнэлгээ авсан тохиолдолд хариуцлага хүлээлгэн арга хэмжээ авах тухай эрх бүхий байгууллагад мэдэгдэн хэрэгжүүлнэ.

--- оОо ---

## ӨМЧ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

20... оны ... сарын ... ны өдөр

№

Алтай хот

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг үндэслэн

НЭГ ТАЛААС: Орон нутгийн өмчийн газрын дарга ажилтай .....

НӨГӨӨ ТАЛААС: ..... байгууллагад  
..... ажилтай .....

Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, Авилгалын эсрэг хуулиудыг удирдлага болгон харилцан тохиролцсоны дагуу энэхүү гэрээг доор дурдсан нөхцөлөөр байгуулав.

1.2. Энэхүү гэрээний зорилго нь Орон нутгийн өмчит хуулийн этгээд /цаашид өмч эзэмшигч байгууллага гэх/-ийн бүртгэлд байгаа эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан үр ашгийг дээшлүүлэхэд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд хяналт тавих, гэрээгээр хүлээсэн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Орон нутгийн өмчийн газрын эрх:

2.1.1. Орон нутгийн өмчийн эзэмшилт ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, бүртгэлд хяналт тавьж, харъяалах хэлтэс, хороод, төлөөлөгч, бусад холбогдох байгууллагатай хамтран болон дангаараа шалгалт хийнэ. Хэрэв өмч эзэмшигч байгууллага гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, өмчид тавих хяналтыг сулруулж, түүнийг үрэгдүүлэх нөхцөл бүрдүүлсэн, өмч хөрөнгийг зохих газрын зөвшөөрөлгүй худалдсан, данс бүртгэлээс хассан, хандивласан, барьцаалсан, түрээслүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах, удирдлагыг өөрчлөх тухай саналаа холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авна. Шаардлагатай гэж үзвэл хуулийн байгууллагад шилжүүлэх

2.1.2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшилт ашиглалтад тавих хяналтын ажилд шаардлагатай бичиг баримт, мэдээ судалгааг холбогдох байгууллага албан тушаалтнаар гаргуулж авна. Тайлан мэдээг гаргаж өгөөгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хожимдуулсан, санаатайгаар буруу гаргасан бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх

2.1.3. Өмч эзэмшигч байгууллагын илүүдэлтэй эд хөрөнгийг түрээслүүлэх, түрээсийн гэрээг бүртгэж хянан баталгаажуулж гурвалсан гэрээ байгуулах

2.1.4. Орон нутгийн өмчийг ашиглах, захиран зарцуулахтай холбогдуулж иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах, шаардлагатай тохиолдолд тодорхой албан тушаалтан, бусад этгээдээс тайлбар, тодорхойлолт гаргуулан авах

2.1.5. Орон нутгийн өмч эзэмшигч байгууллага татан буугдаж үйл ажиллагаа нь зогссон, нэгдэн нийлсэн, хуваагдаж салсан болон бусад хэлбэрээр өөрчлөн зохион байгуулахад төлөөлөл хэрэгжүүлэх

2.2. Орон нутгийн өмчийн газрын үүрэг:

2.2.1. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн тухайн жилийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан үндсэн хөрөнгийг хөрөнгийн бүртгэлийн дараах батлагдсан маягтуудаар гаргаж өмчийн тайланд тусгасан бүртгэлийг гэрээнд хавсаргана. Үүнд:

- а. Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл /ТӨХ-1/
- б. Байгууллагын эзэмшил /ашиглах/ газрын бүртгэл /ТӨХ-2/
- в. Барилга байгууламжийн бүртгэл /ТӨХ-3/
- г. Байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл /ТӨХ-4/
- д. Машин тоног төхөөрөмжийн бүртгэл /ТӨХ-5/
- е. Тээврийн бүртгэл /ТӨХ-6/
- ё. Тээврийн хэрэгслийн бүртгэл /ТӨХ-7/
- ж. Үндсэн сүргийн мал амьтдын бүртгэл /ТӨХ-8/
- з. Худаг, услалтын системийн бүртгэл /ТӨХ-9/
- и. Оюуны өмчийн бүртгэл /ТӨХ-10/
- й. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тухайн жилийн дэлгэрэнгүй мэдээ /ТӨХ-11/

2.2.2. Аймгийн Орон нутгийн өмчийн газар өөрийн эрхийг хэрэгжүүлэх болон өмч эзэмшигч байгууллагад чиг үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай гэж үзсэн мэдээллийг цаг тухайд нь хүргүүлэх

2.2.3. Өмч эзэмшигч байгууллагаас үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэчлэх, их засвар, хөрөнгө оруулалт хийх талаар ирүүлсэн саналыг судалж шийдвэрлэх

2.2.4. Өмч эзэмшиж ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар арга зүйн мэдээлэл, туслалцаа үзүүлэх

2.2.5. Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, бусдад худалдах, шилжүүлэх, данс бүртгэлээс хасах талаар өмч эзэмшигч байгууллагаас зохих журмын дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж биелэлтэд нь хяналт тавих

## **Гурав. ӨМЧ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### **3.1. Өмч эзэмшигч байгууллагын эрх**

3.1.1. Өмч эзэмшигч байгууллага нь өөрийн мэдэлд буй эд хөрөнгийг зохих хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэмдээ нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу зориулалтын хүрээнд эдэлгээний хугацаа, ашиглалтын горимыг чанд мөрдөн, ариг гамтай эзэмшиж ашиглана.

3.1.2. Тухайн байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг зохих журмын дагуу шийдвэрлэх

3.1.3. Байгууллагын эд хөрөнгийг олж авах, шилжүүлэх, худалдах, засвар өөрчлөлт хийх шинээр хөрөнгө оруулахад холбогдох эрх бүхий байгууллагад саналаа тавьж зохих журмаар шийдвэрлүүлэх

3.1.4. Хөрөнгийг хадгалах, ашиглах явцад буруутай этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх

3.1.5. Байгууллагын эзэмшиж буй хөрөнгийг зохих журмын дагуу бусдад түрээслүүлэх

3.1.6. Эрх бүхий байгууллагаар өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалтын талаар үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах

### **3.2. Өмч эзэмшигч байгууллагын үүрэг**

3.2.1. Төрийн өмчийн хорооны 2010 оны 2 сарын 4-ний өдрийн 36 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан жилийн мэдээ, тайланг заасан

хугацаанд гаргаж аймгийн Орон нутгийн өмчийн газарт тайлагнах

3.2.2. Байгууллагын эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих хяналтыг зохион байгуулж, эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журам, хугацааны дагуу явуулж, түүний үнэн зөвийг болон эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдлыг бүрэн хариуцах

3.2.3. Хөрөнгийг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж хөтлөх

3.2.4. Эрх бүхий байгууллагаас үндсэн хөрөнгийн үнэлгээнд өөрчлөлт оруулахаар шийдвэр гаргасан тохиолдолд холбогдох дүрэм, журам, зааврын дагуу тухай бүр шинэчлэн үнэлгээ хийж бүртгэлд тусгах

3.2.5. Хандив, бэлэглэлийн хэлбэрээр өгсөн үндсэн хөрөнгийг журмын дагуу бүртгэж шинээр бүртгэсэн болон данснаас хассан хөрөнгийг тухайн жилийн эцэст "Төрийн болон орон нутгийн мэдээлэлжүүлэх систем"-д оруулж баталгаажуулах

3.2.6. Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төсөвт өртөгөөс хамааруулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 22 дугаар тогтоолыг мөрдлөг болгон ажиллах

3.2.7. Өмч эзэмшигч байгууллагын дарга /захирал/ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу байгууллагадаа Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулж ажиллуулах

3.2.8. Эд хөрөнгийг өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэж гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, үрэгдүүлж алга болгосон ажилтан, албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулан учирсан хохирлыг нөхөн төлүүлж энэ тухай албан ёсоор мэдэгдэж байх

3.2.9. Байгууллагын дарга /захирал/ нь Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гаргасан дүгнэлтийг үндэслэн эзэмшилдээ байгаа илүүдэлтэй үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан, осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах зэрэг асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 22 дугаар тогтооны дагуу шийдвэрлүүлнэ.

3.2.10. Өөрийн болон бодлого, чиг үүргээр харьяалагдах бие даасан нэгжийн барилга байгууламжид өргөтгөл, их засвар хийх тохиолдолд аймгийн Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авах

#### **Дөрөв. ГЭРЭЭ БАЙГУУЛАГЧ ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

4.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдож үүссэн аливаа асуудлын талаар хоёр тал харилцан зөвлөлдөнө.

4.2. Гэрээний биелэлтийг тайлант оны дүнгээр тухайн байгууллагын төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүгийн тайлан тэнцэл, холбогдох бусад мэдээллийг үндэслэн хоёр тал харилцан тохиролцож дараа оны 2-р улиралд багтаан дүгнэнэ.

4.3. Гэрээний биелэлтийг дүгнэхэд өмч эзэмшигч байгууллагын дарга /захирал/ нь өөрт бодлого, чиг үүргээр харьяалагдах бие даасан нэгжтэй бол энэхүү гэрээний загвараар дотооддоо гэрээ байгуулж, тухайн жилд байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хамтад нь тайлагнана.

4.4. Өмч эзэмшигч байгууллага өөрчлөн зохион байгуулагдсан, удирдлага солигдсон тохиолдолд энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл гэрээг шинэчлэн байгуулах талаар

шинээр томилогдсон даргатай санал солилцон тохиролцож аймгийн Орон нутгийн өмчийн газартай хөрөнгийн ашиглалт, чанар, үр ашгийн үзүүлэлтийг тодорхойлж, хөрөнгийг актаар хүлээлцүүлнэ.

4.5. Гэрээ байгуулагч талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй бол нөгөө тал нь уг үүргийг гүйцэтгэхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасны дагуу буруутай этгээд нь хариуцлага хүлээнэ.

4.6. Гэрээгээр тодорхойлсон заалт нь талуудын хууль ёсоор хүлээх хариуцлагыг өөрчлөх үндэслэл болохгүй.

#### **Тав. БУСАД ЗҮЙЛ**

5.1. Энэхүү гэрээ нь түүнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

5.2. Өмч эзэмшигч байгууллагыг хувьчилсан, татан буулгасан тохиолдолд гэрээг цуцалсанд тооцож, үндсэн хөрөнгийн тооллого явуулж тооцоо хийнэ.

5.3. Гэрээнд зөвхөн талуудын тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.4. Орон нутгийн өмчийн эзэмшлийн гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.

5.5. Гэрээ цуцлагдаагүй нөхцөлд гэрээг үргэлжлүүлж, гэрээ дүгнэх журмын дагуу жил бүр гэрээг дүгнэж ажиллах ба гэрээнд хавсаргах хөрөнгийн жагсаалт тухайн жилийн тооллогын дүнгийн батлагдсан маягаар хийсэн жагсаалт байна.

#### **ГЭРЭЭНИЙ ТАЛУУД:**

*/тамга/* Орон нутгийн өмчийн  
газрыг төлөөлж:

.....  
*/овог, нэр/*

.....  
*/Албан тушаал/*

Утас.....

*/тамга/* Байгууллагыг  
төлөөлж:

.....  
*/овог, нэр/*

.....  
*/Албан тушаал/*

Утас.....



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 20 <sup>18</sup> оны  
<sup>03</sup> дугаар сарын <sup>22</sup> ны өдрийн <sup>23</sup> дугаар  
 тогтоолын 3 дугаар хавсралт

**ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГЫН ГЭРЭЭНИЙ  
 БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХҮСНЭГТ**

№	Гэрээ дүгнэх болзол	Олгох дээд оноо	Олгосон оноо	Биелэлт /хувиар/	Тайлбар
<b>А.</b>	<b>Хөрөнгийн хөдөлгөөний талаар:</b>				
1	Төсвийн санхүүжилт болон хэмнэлт, өөрийн орлогоос шинээр үндсэн хөрөнгө худалдан авсан, худалдсан, шилжүүлсэн, акталсан болон хөрөнгө оруулалт хийхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал	10			
2	Төсвийн хөрөнгө оруулалт, хандив, тусламж, бэлэглэл, төслийн хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийг холбогдох журмын дагуу бүртгэн авч балансад тусгасан байдал	10			
3	АИТХТ-ийн тогтоол, ОНӨГ-ын шийдвэрээр акталж хоёрдогч түүхий эд болгон ашиглах хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байдал	5			
Дүн		<b>25</b>			
<b>Б.</b>	<b>Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын талаар:</b>				
1	Эзэмшиж буй өмч хөрөнгийн эдэлгээний хугацаа, ашиглалтын горимыг чанд мөрдөн, бүрэн бүтэн байлгаж, ариг гамтай эдэлсэн болон барилгын хувийн хэрэг, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт хөтлөлтийн байдал болон өмчийн харилцааны чиглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт	5			
2	Үндсэн хөрөнгийн дотоодын тооллогыг хуулийн дагуу, үнэн зөв, чанартай явуулж тайлагнасан, илэрсэн зерчил дутагдлыг арилгах, хариуцлага тооцсон болон илүүдэл, дутагдлыг данс бүртгэлд тусгасан байдал	5			
3	Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөс хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар бодитой ажил хийсэн ажлын үр дүн	5			
4	Үндсэн хөрөнгө данснаас хасах талаар гаргасан дүгнэлт үнэн зөв, баримтын бүрдэл хангасан байдал, актлах, худалдахаар шийдвэрлэсэн хөрөнгийг зохих журмын дагуу хийж, акт үйлдсэн болон шийдвэрийн биелэлтийг Орон нутгийн өмчийн албанд ирүүлсэн байдал	5			
5	Эд хариуцагч нартай хариуцлагын гэрээ байгуулан ажилладаг эсэх болон агуулах, складын ариун цэвэр эмх цэгцийн байдал	5			
Дүн		<b>25</b>			

<b>В. Түрээсийн талаар:</b>				
1	Илүүдэлтэй байр талбай болон хөрөнгийг бусдад түрээслэхдээ холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу гэрээ байгуулж батлуулсан байдал	5		
2	Түрээсийн орлогын зохих хувийг төсвийн дансанд цаг хугацаандаа бүрэн төвлөрүүлсэн байдал болон түрээсийн гэрээний хэрэгжилтийн байдал	5		
Дүн		10		
<b>Г. Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системийн бүрдүүлэлт</b>				
1	"Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгө болон бүртгэл, статистикийн мэдээлэл, тэдгээрийн хөдлөл өөрчлөлт, холбогдох баримт материалыг иж бүрэн тайлагнаж, баталгаажуулсан байдал	15		
Дүн		15		
<b>Д. Байгууллагын эзэмшил газрын талаар:</b>				
1	Байгууллагын эзэмшил газрыг баталгаажуулсан болон баримтын бүрдэл хангасан байдал,	5		
2	Газрын эзэмшил, ашиглалт, нийтийн эзэмшил газрын тохижилтын байдал болон газартай холбогдон үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлэсэн байдал	5		
Дүн		10		
<b>Е. Бэлтгэл ажлыг хангасан талаар:</b>				
1	Үндсэн хөрөнгийн хөдөлгөөний тайлан гаргасан байдал, иж бүрдэл	5		
2	Журамд заасан болон бүрдүүлбэл зохих материалыг бэлтгэсэн байдал	5		
3	Байгууллагад нэмж бүртгэлд авсан үндсэн хөрөнгийн хөдөлгөөний дэлгэрэнгүй тайлангийн бүрдлийн байдал	5		
Дүн		15		
<b>НИЙТ ДҮН</b>		<b>100</b>		

ҮНЭЛГЭЭ:

Үнэлгээ	Олгох дээд оноо:	Олгосон оноо: /тоо, үсгээр/
"Бүрэн хангалттай"	96-100 оноо /96-100%/	
"Хангалттай"	76-95 оноо /76-95%/	
"Хангалтгүй"	75-аас доош оноо /75%-с доош/	

Жич: Зөвхөн **Тайлбар** баганыг бөглөөд гарын үсэг зураад тамга дарж ирүүлнэ.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

Орон нутгийн өмчийн газрын  
мэргэжилтэн: .....

..... /

/

/гарын үсэг/

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

.....

Байгууллагын дарга: .....

..... /

/

Байгууллагын ерөнхий  
ня-бо: .....

..... /

/

/гарын үсэг/

ХЯНАСАН:

Орон нутгийн өмчийн газрын

дарга: .....

..... /

/

/гарын үсэг/